

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ

ТОГТООЛ

2013 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Хорооны 2013 оны 249, 250 дугаар тогтоолоор батлагдсан

журам, шаардлагад нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.3, 14.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцох журам”-д дор дурьдсан агуулгатай 3.2.19, 3.2.20 дахь заалт болон хавсралтад мөр нэмсүгэй:

1/ 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 19, 20 дахь заалт:

“3.2.19. Компанийн хувьцаа 10 хувь;

3.2.20. Банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө 5 хувь”

2/ Мөн журмын хавсралтын “Зөвшөөрөгдөхгүй хөрөнгийг тооцох аргачлал” гэсэн хэсгийн “Бусад хөрөнгө” гэсэн мөрийн дор дараах агуулгатай мөр нэмсүгэй.

3.19 Компанийн хувьцаа	15%		5%		0%		
3.20 Банк бус санхүүгийн байгууллагад төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө	5%		1%		0%		

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 250 дугаар тогтоолоор батлагдсан “Ердийн даатгалын компанийн нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага”-д дор дурьдсан агуулгатай 5.1.8, 5.1.9 дахь заалт нэмсүгэй:

1/ 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8, 9 дэх заалт:

“5.1.8. Компанийн хувьцаа 10 хувь, нэгжид ногдох 5 хувь;

5.1.9. Банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулсан мөнгөн хөрөнгө 5 хувь”

2. Мөн журмын хавсралтын “Даатгалын компанийн нөөц сангийн хөрөнгө оруулалтын тайлан” гэсэн хэсгийн “Бусад хөрөнгө” гэсэн мөрийн дор дараах агуулгатай мөр нэмсүгэй.

7. Компанийн хувьцаа	15%	5%	
8. Банк бус санхүүгийн байгууллагад төвлөрүүлсэн хөрөнгө	5%	1%	

4. Дээрх журамд нэмэлтийг оруулж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х. Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН